



“МЕРЕКС” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 08-р сарын 28-ний өдөр

№ 10-1

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60, 62 64, 65 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12-р сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Мерекс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2024 оны 10 сарын 07-ний өдрийн 11:00 цагт Барилга Архитектур Корпорацийн байр 4 давхар 419 тоотод ХУРАДУУЛСУГАЙ.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр ОРУУЛСУГАЙ.
 - 2.1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах
 - 2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
 - 2.3. Ногдол ашиг хуваарилахгүй тухай
 - 2.4. Бусад
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах Бүртгэлийн өдрийг 2024 оны 09 сарын 12-ны өдрөөр ТОГТООСУГАЙ.
4. Компанийн ээлжит бус хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2024 оны 08 сарын 28 өдөр, өдөр тутмын хэвлэлээр мэдээлэх, энэ мэдээллийг дээрх хэлбэр шаардлагын дагуу анх мэдээлсэн өдрөөс 15 хоногийн дараа буюу 2024 оны 09 сарын 12 өдөр дахин мэдээлэхийг ТУЗ-ийн нарийн бичиг ДААЛГАСУГАЙ.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлаар хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн санал авах “Саналын хуудас”-ын агуулыг Хавсралт №1-ээр БАТАЛСУГАЙ.
6. Хувьцаа эзэмшигчээс “Саналын хуудас”-ыг харъяалагдах брокер, дилерийн компаниар дамжуулан хүлээн авах сүүлийн өдрийг 2024 оны 10 сарын 07 өдөр байхаар ТОГТООСУГАЙ.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг удирдах хурлын даргаар Г.Бямбабаяр, тооллогын комисст “Мерекс” ХК-ийн Технилогч инженер А.Батцэцэг даргаар, нарийн бичиг Д.Уянга нарыг гишүүдээр тус тус ТОМИЛСУГАЙ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.БЯМБАБАЯР



"МЕРЕКС" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 08-р сарын 26-ний өдөр

№ 0-2

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

Компанийн тухай хуулийн 46,5 дахь заалтыг үндэслэн, 2023 онд ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн тухай хуулийн 47.1.2 дахь заалтад заасан нөхцөл хангадаагүй тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар ТОГТООСУГАЙ.
2. Компанийн тухай хуулийн 46.6 дахь заалтад заасны дагуу ногдол ашиг хуваарилахгүй байх үндэслэлийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд тайлагнахыг ТУЗ-ийн дарга Г.Бямбабаяр-т ҮҮРЭГ БОЛГОСУГАЙ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.БЯМБАБАЯР



“МЕРЕКС” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 08-р сарын 26-ний өдөр

№ 10-3

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан болон түүнд хийгдсэн хараат бус аудитын тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийн тухайд

Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалт, “Мерекс” ХК-ийн 2024 оны 08 сарын 26 өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын дүнг үндсэлэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч БАТАЛСУГАЙ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.БЯМБАБАЯР